

ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

IMPROVING THE PREVENTIVE WORK OF CRIMES COMMITTED BY JUVENILE

В.Номинчулуун

*ДХИС-ийн ЭШНХ-ийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний ажилтан, цагдаагийн ахмад*

Э.Хандармаа

*ДХИС-ийн ЭШНХ-ийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний ажилтан, цагдаагийн дэслэгч*

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эцэг эх, сурган хүмүүжүүлэгч, олон нийтийг хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцуулах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж боловсруулахыг зорьсон.

Abstract: In this article, we aim to put forward suggestions and recommendations for the prevention of crimes committed by juvenile, to increase the attitude of parents, educators, and the public against the crimes of juvenile, and to improve the prevention of this type of crime and violations.

Түлхүүр үгс: Хүүхэд, гэмт хэрэг, шалтгаан, нөхцөл, хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх ажил.

Keywords: Juvenile, crime, causes, factors, preventive work.

Ирээдүй хойч болсон бяцхан үрс маань гэмт хэрэг үйлдэх тохиолдол нэмэгдэх хандлагатай байна. Ялангуяа нийгмийн стресс, бухимдал ихтэй энэ цаг үед үр хүүхдүүддээ тавих хараа хяналт, тэдэндээ зориулах цаг хугацаа дэндүү хомс байгаа нь үүний учир шалтгаан болж байна. Мөн хайхрамжгүй байдал, гэр бүл салалт зэргээс шалтгаалж бага насны хүүхдүүд гэмт хэрэгт холбогдох тохиолдол цөөнгүй байна.

Насанд хүрээгүй хүнээс тодорхой газар нутаг, тодорхой цаг хугацаанд үйлдсэн гэмт хэргүүдийн нийлбэрийг насанд хүрэгчдийн гэмт явдал гэж тусгайлан авч үзэж судалдаг тогтсон нийтлэг хандлага байдаг бол “хүүхдийн гэмт явдал” гэж насанд хүрээгүй хүмүүсийн бие бялдрын, оюун санааны, зан суртахууны хүмүүжлийг төлөвшүүлж байгаа тэр нийгмийн харилцааг шууд зөрчиж байгаа нийгэмд аюултай гэмт халдлага юм⁶³ гэсэн дүгнэлтийг ОХУ-ын эрдэмтэд хийжээ.

Хүүхдийн үйлдэж байгаа болон хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт явдлын хооронд нөхцөл байдлын тодорхой холбоос байна гэж зарим эрдэмтэд⁶⁴ үздэг.

Хүүхэд нь сэтгэл зүйн хувьд бүрэн гүйцэд төлөвшөөгүй, ертөнцийг үзэх үзэл тогтоогүй байдаг учир түүнийг хүрээлж буй гэр бүл, эцэг, эх, найз нөхөд, ойр дотны хэн нэгний нөлөөнд хялбар автдаг. Энэ байдал нь орчны таагүй нөлөө /согтууруулах ундаа хэрэглэх, мансуурах байдалд орох/-өөр амархан өдөөгдөж сөрөг зан төлөвтэй болох, гэмт хэрэг үйлдэх, гэмт халдлагад өртөхөд хүргэдэг⁶⁵.

Хүүхдээс үйлдсэн гэмт явдлыг криминологийн судалгааны бие даасан хэсэг болгон үзэх нь хэд хэдэн шалтгаантай байна.

1. Өсвөр үеийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах, арга хэмжээний цар хүрээг чухалчлан үзэх шинж чанараараа, мөн хүүхэд залуу үеийн ашиг сонирхол эрхийг хамгаалах талаарх төрийн бодлого, төрийн болон нийгмийн бие даасан үйл ажиллагааг чиглүүлэхэд чиглэгдсэн байдаг.

⁶³ Уголовное право. Особенная часть: Учебник /Под ред. проф. В.Н.Петрашева. -М., 1999. С.138.

⁶⁴ Там же, Эмирбекова Э.Э. Преступления против несовершеннолетних и проблемы их профилактики /по материалам республики Дагестан/. Дис...докт. юрид. наук. М. 2006. С.115.

⁶⁵ Бадамханд Ю. Хүүхдийн эсрэг гэмт явдал. УБ. 2014. 63 дахь тал.

2. Хүүхдийн хүмүүжил, амьдралын үйл ажиллагааны онцлогоос хамаарсан гэмт хэргийн шалтгаан гарал үүслийн онцгой шинж чанараар тодорхойлогдоно.

3. Гэмт явдлын бүтэц, төвшний төрөл, түүний шалтгаан явц өсвөр насны хүүхдүүдийн гэмт явдлын идэвхжилт өндөр байгаатай холбож үзнэ.

Өсвөр насандаа гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүд засрахдаа тун хэцүү байдаг бөгөөд давтан болон насанд хүрсэн хүмүүсийн гэмт явдлын үндсэн бэлтгэл хүч болдог.⁶⁶

Анх удаа гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүмүүст урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авах нь цаашид гэмт хэрэгт холбогдох явдлаас хамгаална. Хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг өсөх хандлагатай байгаа нь тэдгээрийн үйлдэж байгаа гэмт хэргийн тоон үзүүлэлтээс илүү тодорхой харагдаж байна.

График №1. Нийт бүртгэгдсэн болон хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн харьцуулалт.



Улсын хэмжээнд 2022 онд 35340 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9911 хэргээр буюу 39 хувиар, насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг 1258 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 525 хэргээр буюу 71.6 хувиар тус тус өсөж, бүх хэрэгт эзлэх хувийн жин 3.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.7 нэгжээр өссөн байна.

2023 оны эхний 4 сарын байдлаар 272 хүүхэд гэмт хэрэгт холбогдсон байна⁶⁷. Иймд хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн тоо цаашид өсөх хандлагатай байгаа тул энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

График №2. Хүүхэд үйлдсэн гэмт хэргийн ангилал.



Дээрх хүснэгтээс харахад, хүүхдээс үйлдэгдсэн гэмт хэргийн 1036 буюу 82.4 хувийг хөнгөн, 222 буюу 17.6 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж байгаа бол 68.2 хувь нь Улаанбаатар хотод, 31.8 хувь нь орон нутагт тус тус бүртгэгдсэн байна.

⁶⁶ Мөн тэнд. 259 дэх тал.


⁶⁷ Цагдаагийн ерөнхий газар. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал – 2022. УБ. 2023. 5 дахь тал.

Хүснэгт №1.Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тоон мэдээ /Гэмт хэргийн төрлөөр/

Гэмт хэргийн төрөл	Хэргийн тоо			Хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн эзлэх хувь
	2021 он	2022 он	Өсөлт, бууралт /хувиар/	
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	230	327	42.2	26.0
Хүнийг алах	1	9	9.0	0.7
Хүчиндэх	19	30	57.9	2.4
Бэлгийн мөлжлөг	1		-100	0.0
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	395	727	84.1	57.8
Үүнээс	Хулгайлах	257	273	6.2
	Залилах	117	398	3.4
	Дээрэмдэх	21	56	2.7
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	9	5	-44.4	0.4
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	7	5	-28.6	0.4
ХАБТХАЖЭ	17	15	-11.8	1.2
Бусад	54	140	2.6	11.1


Дээрх хүснэгтээс үзэхэд, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хулгайлах, залилах гэмт хэрэг он дараалан өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэрэгт 1540 хүүхэд холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 619 буюу 647.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хулгайлах гэмт хэрэг өсөж байгаа нь эдийн засгийн хомсдол, эцэг эхийн хараа хяналтгүй байдал, үе тэнгийнхний дарамт шахалт, эд хөрөнгө эзэмших хүсэл зэрэг нь нийтлэг өдөөгч хүчин зүйл болж байна.

График №3. Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн гараг, цаг, газрын мэдээлэл.



Хүснэгтээс харахад 14-19 цаг буюу өдрийн цагаар 396 буюу 31.5 хувь, даваа, мягмар гарагт хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг хамгийн ихээр бүртгэгдсэн тоон мэдээлэлтэй байгаа нь эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ тавих хараа хяналт муу байгааг харуулж байна.


График №4. Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газрын мэдээлэл.



Дээрх хүснэгтээс харахад, гэр, орон сууцанд 407 буюу 32.4 хувь, гудамж, талбайд 355 буюу 28.2 хувь нь бүртгэгдсэн байна.

Иймд даваа, мягмар гарагт 14.00-19.00 цагийн хооронд гудамж, талбай, гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байгаад анхаарч цагдаагийн байгууллага энэ төрлийн дуудлага нэг бүрд хуулийн дагуу оновчтой арга хэмжээ авах, дээрх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг идэвхжүүлэх, эргүүл шалгалтыг тогтмол явуулах, иргэд энэ төрлийн гэмт хэргийн хажуугаар дуугүй өнгөрдөггүй, мэдээлэлдэг, шаардлага тавьдаг, анхаарал хандуулдаг байх шаардлагатай байгаа нь тоон үзүүлэлтээс харагдаж байна.

График №5. Насанд хүрээгүй холбогдогчдын нас, хүйс, боловсролын байдал.



Эндээс үзэхэд, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн 376 буюу 24.4 хувь нь эмэгтэй, 1164 буюу 75.6 хувь нь эрэгтэй хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 5.9 дахин, эрэгтэй хүүхэд 35.8 хувиар тус тус өссөн байна. 15 хүртэлх насны хүүхэд 628 буюу 53.9 хувийг эзэлж байгаа нь бага насны хүүхдээ эцэг эхчүүд сургуульд нь өөрийн биеэр хүргэж өгөх, цагт нь авах, мөн өсвөр насны хүүхдийнхээ багш сурган хүмүүжүүлэгчтэй нь тогтмол уулзаж, юу хийж хаагуур явж байгааг нь ажиглан анхаарал тавих, хүүхдээ гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авах шаардлагатай нь харагдаж байна.

Гэмт хэрэг гарахад нийгэм, эдийн засаг, эрх зүйн шинжтэй олон хүчин зүйл нөлөөлдөг боловч гэр бүлийн орчин, эцэг, эхээс хүүхдэд тавих анхаарал халамжтай холбоотой дараах нөхцөл байдлууд хүүхдийн хүмүүжил, ухамсарт нөлөөлөх гол шалтгаан болж байна. Үүнд:

1. Бусдын нөлөөнд амархан автах. Хүүхэд сэтгэлзүй, зан төлөв, оюун ухааны хувьд бүрэн гүйцэт төлөвшөөгүй байдаг учир түүнийг хүрээлж буй гэр бүл, эцэг, эх, найз нөхөд, ойр дотны хүмүүсийн нөлөөг давтахад маш амархан. Орчин тойрны хүмүүсийн ааш, зан яриа өгүүлэл, биеэ авч яваа байдал, бусдын үлгэргүй байдлаас шалтгаалж

хүүхэд буруу зүйлийг илүү сонирхох, суралцах, үзсэн зүйлээ туршихыг хүсэх нь улмаар гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг.

2. Амар хялбар аргаар мөнгөтэй болох хүсэл. Насанд хүрээгүй хүний тухайд эдийн засгийн хувьд бусдаас хараат байдгаараа онцлог байдаг. Өөрөөр хэлбэл хоол хүнс, хувцас, орон байрны хэрэгцээг түүний эцэг, эх болон харгалзан дэмжих үүрэгтэй хүмүүс хангаж байдаг. Хүүхэд өөрийнх нь хэрэгцээг хангаж чадахгүй нөхцөлд амьдралын түвшин хамаарахгүйгээр гэмт хэрэг үйлдэж, олсон мөнгөөрөө хоногийн хоол хүнс, хэрэгцээт зүйлс авахаасаа илүүтэй цахим тоглоом тоглох, , үзвэр үзэх зэргээр зугаацахад зарцуулж байна.

3. Чөлөөт цагийг өнгөрүүлэх газар дутмаг. Хүүхдэд зориулсан биеийн тамирын талбай, тоглоомын төв, усан бассейн, спортын цогцолбор, хүүхдийн ордон зэрэг чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх газар хомс, үйл ажиллагаа явуулж байгаа зарим газрууд нь өндөр төлбөртэй байгаагаас хичээлийн бус цагаар хэсэг бүлгээрээ нийлж, гадуур тэнэж сэлгүүцдэг.

4. Гэр бүлийн орчин. Хүүхдийн буруу хүмүүжил, нийгэмд харш зан төлөв нь гол төлөв гэр бүлийн хүрээнд тогтдог бөгөөд гэр бүл дэх таагүй уур амьсгал, архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салах зэрэг нь хүүхдэд сөргөөр нөлөөлж байнгын стресст орох, уур бухимдлаа бусдад гаргах, хүчирхийлэл үйлдэхэд хүргэдэг.

5. Хүүхдийг зөв хүн болгон төлөвшүүлэхэд чиглэгдсэн хичээл сургалтын чанар. Ерөнхий боловсролын сургуулиудад “Иргэний боловсрол” болон “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа” хичээлээр сурагчдад гэмт хэрэг, зөрчил, гэмт хорын тухай ойлголтыг тодорхой цагаар заадаг боловч хичээлийн агуулга нь өнөөгийн шаардлагатай уялдаагүй, багшлах боловсон хүчин дутмаг зэрэг шалтгаанаар төдийлөн үр дүнд хүрэхгүй байгаа. Сурагчдын тоо олон, зарим үед 3 ээлжээр хичээллэдэг учир хичээлийн бус цагаар хүүхдийн хүмүүжилд чиглэсэн ажил, арга хэмжээ бараг зохион байгуулагддаггүй.

6. Хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилт хангалтгүй. Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас эрх нь зөрчигдсөн хүүхдийн асуудлаар “Хүүхдийн хууль зүйн хороо”, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн асуудлаар “Хамтарсан баг” ажиллахаар заасан боловч хэрэгжилт нь хангалтгүй, стандарт MNS 6444:2014 буюу “Сургуулийн бүс”-ийн техникийн ерөнхий шаардлагын дагуу сургуулийн орчныг тохижуулаагүй, сургуулийн автобусны тоо бага, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн талаар эцэг, эх, сурагчдын мэдлэг хомс, эцэг, эхчүүд хүүхдийг зориулалтын дагуу тээвэрлэдэггүй, бага насны хүүхдийг ганцааранг нь замын хөдөлгөөнд оролцуулдаг, эсхүл хүүхдийг хүүхдэд нь даатгаж /ах, эгчээр нь хүргүүлэх гм/ хөдөлгөөнд оролцуулдаг зэрэг байдлууд нь хүүхэд зам тээврийн осолд өртөхөд ихээр нөлөөлж байна.

7. Цахим орчин дахь хяналтгүй, сөрөг мэдээлэл. Мэдээллийн технологи, цахим орчин, гар утас нь хувь хүн, нийгмийн амьдралд шинэ дэвшлийг авч ирсэн хэдий ч энэ нь хүүхдийн тухайд садар самуун, хүчирхийлэл, гэмт хэргийн тухай санаа, сэдэл өгч, донтолт, ганцаардлыг бий болгох гол нөхцөл болсоор байна. Тухайлбал: Хүүхэд өсвөр үеийнхний бие бялдар, оюун санаа, нийгэмшихүйд туйлын муу сөрөг нөлөөтэй гэдэг нь олон улсын болон үндэсний түвшний судалгаануудаас тодорхой харагдаж байна.

Өнөөдөр манай улсын хувьд нийт хүн амын 34.6 хувийг 0-18 насны хүүхэд эзэлж байгаа бөгөөд хүүхдийн эрхийг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд гэр бүл, эцэг, эх бидний оролцоо хамгийн чухал юм.

Учир нь хүүхдийн өв тэгш хүмүүжил, төлөвшилд гэр бүлийн халуун, дулаан уур амьсгал нэн чухал төдийгүй аз жаргалтай, бие биеэ ойлгодог, хүндэлдэг, сонсдог гэр бүлд хүүхэд бие бялдар, оюун ухааны хувьд өв тэгш хүмүүждэг байна.

Хүүхдийг зөв хүн болгон хүмүүжүүлэх, төлөвшүүлэх асуудал бол гэр бүл, эцэг эхээс шууд хамаардаг гэдгийг бид бүхэн мэддэг хэдий ч, өдөр тутмын алба, амины ажил гэж зүтгэсээр... нэг л мэдэхэд хүүхэд гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн улмаас эрх ашиг нь хохирох, хүчирхийлэлд өртөх, зам тээврийн осолд орох, хаягдах, төөрөх,

архидан согтуурах, мансуурах, цахим тоглоомд донтох, биеэ үнэлэх, гал түймэр, гол усны аюул, ахуйн осолд өртөх зэрэг олон асуудлын улмаас амь нас, эрүүл мэнд нь хохирсоор байна.

Хүүхдээ зөв хүн болгон хүмүүжүүлэх, төлөвшүүлэх, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах нь зөвхөн сайн эцэг, эхийн ухамсар, амьдралын туршлагатай холбоотой бус, бүх эцэг, эхчүүдийн хуулиар хүлээсэн заавал биелүүлэх ёстой үүрэг болоод байна. Энэ талаар Хүүхдийн эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Хүүхдийн хүмүүжил, төлөвшил”-ийн талаар, 10 дугаар зүйлд “Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг, хариуцлага”-ын талаар тодорхой тусгасан байдаг.

Зөрчлийн тухай хуульд “Хүүхдийн эрхийг зөрчих” гэсэн бүлгийг шинээр оруулж хүүхдийн эрхийг хангах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, хүүхдийн дэргэд архидан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хоёр зуун нэгжээс гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, дээрх үйлдлийн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хор уршиг учирсан, амь нас хохирсон бол Эрүүгийн хуулийн 16.11 дүгээр зүйлд заасны дагуу дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Цагдаагийн байгууллагаас Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр Цагдаагийн албаны тухай хуульд тусгайлсан заалтыг оруулж, холбогдох журмуудыг боловсруулан батлуулж, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр чиг үүргийнхээ хүрээнд хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг, өдөрлөг, сургалт, сурталчилгааны ажлуудыг тасралтгүй зохион байгуулж, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй хүүхдэд захиргааны хяналт тогтоох, хараа хяналтгүй хүүхдийн асуудлыг шийдэхэд тусалцаа үзүүлэх зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулж байгаа боловч хүүхэд бүрд хүрч чадахгүй байна.

Дүгнэлт

Хүүхдийг хариуцлагатай, хуулиа сахидаг хүн болгон төлөвшүүлэх нь бидний үүрэг юм. Хүүхэд гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй үндсэн хүчин зүйлсийг шийдвэрлэснээр бид хүүхдүүдийг эерэг замд хөтөлж, тэдний сайн сайхан байдал, нийгмийнхээ аюулгүй байдлыг хангах боломжтой болно. Хүүхэд бүрийн чадавхыг хүлээн зөвшөөрч, тэднийг хөгжүүлэх, нийгэмд эергээр хувь нэмэр оруулахад шаардлагатай арга хэрэгслээр хангаж, дэмжлэг үзүүлэх, суурь асуудлуудыг шийдвэрлэх, боловсрол олгох, амьдрах ухаанд сургах, гэр бүл, хамт олныг бэхжүүлэх замаар бид хүүхдүүдийг гэмт хэргийн эргэлтээс ангижруулж, гэрэлт ирээдүйтэй болоход нь тусалж чадах учраас дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд, доорх чиглэлээр сайжруулалтын ажил, арга хэмжээ явуулах нь үр дүнтэй. Үүнд:

Гэр бүл, олон нийтийн харилцаа холбоог бэхжүүлэх: Гэр бүл, олон нийтийн хүчтэй дэмжлэг нь хүүхдийг гэмт хэргээс холдуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүүхэд хүмүүжүүлэх эрүүл арга барилыг сурталчлах, гэр бүлийн эерэг динамикийг бий болгох, эцэг эхийн сургалтын хөтөлбөрийг санал болгох нь хүүхдийг хүмүүжүүлэх орчныг бүрдүүлэхэд тусална. Хүүхдийн эрч хүч, бүтээлч сэтгэлгээг бий болгоход чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагаа, спортын клуб, цагаа зөв боловсон өнгөрүүлэх газруудыг ихээр байгуулж, хамтдаа байх мэдрэмж, эерэг үлгэр дуурайллыг бий болгосноор бид хүүхдүүдэд илүү сайн сонголт хийх боломжийг олгоно.

Боловсрол ба ур чадварыг хөгжүүлэх: Хүүхдүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд боловсрол чухал үүрэг гүйцэтгэдэг. Сургуульд харьяалагдах мэдрэмжийг төрүүлж, эрдэм шинжилгээний ажилд идэвхтэй оролцох, нийгмийн болон сэтгэл

хөдлөлийн ур чадварыг хөгжүүлэх хүмүүжлийн орчныг бүрдүүлэх ёстой. Амьдрах ухааны боловсрол, зөрчилдөөнийг шийдвэрлэх сургалт, зан чанарыг төлөвшүүлэх үйл ажиллагааг сургалтын хөтөлбөрт тусгаснаар хүүхдийг эерэг сонголт хийхэд шаардлагатай хэрэгслээр хангана. Нэмж дурдахад мэргэжлийн сургалт, дагалдан сургах хөтөлбөрүүд нь амжилтад хүрэх өөр арга замуудыг өгч чадна.

Цахим аюулгүй байдлын арга хэмжээ: Хүүхдийн насанд нь тохирсон интернэтийн хэрэглээний удирдамжийг бий болгож, мөрдүүлэх, хүүхдүүдэд онлайн аюулгүй байдлын талаар мэдлэг олгох нь амин чухал юм. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ цахим орчинд хийж буй үйл ажиллагаанд идэвхтэй хяналт тавьж, нээлттэй харилцаа холбоо тогтоож, хувийн мэдээллээ хуваалцах, танихгүй хүмүүстэй харилцах, цахим хүчирхийлэлд өртөх зэрэгт учирч болзошгүй аюулын талаар тэдэнд мэдлэг олгох хэрэгтэй. Эцэг эх, сурган хүмүүжүүлэгч, интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдийн хамтын ажиллагаа нь хүүхдэд аюулгүй онлайн орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Сэтгэцийн эрүүл мэнд, зөвлөгөө өгөх үйлчилгээ: Гэмт хэрэг үйлдэж буй олон хүүхдүүд сэтгэцийн эрүүл мэндийн асуудал эсвэл шийдэгдээгүй гэмтэлтэй байж болно. Хүүхдэд зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, боломжийн үнээр хангах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Сургууль, олон нийт эрсдэлт бүлгийн хүүхдүүдийн онцгой хэрэгцээнд тохирсон зөвлөгөө, эмчилгээ, тусламжийн бүлгүүдийг үзүүлэхийн тулд сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах ёстой. Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудыг эрт илрүүлэх нь зохих арга хэмжээ авах замыг нээж, гэмт хэрэгт холбогдох магадлалыг бууруулдаг.

Эрт хөндлөнгийн оролцоо ба дэмжлэг: Эрсдэлийн бүлгийн хүүхдүүдийг тодорхойлж, тэдэнд чиглэсэн дэмжлэг, хөндлөнгийн хөтөлбөрөөр хангах нь хүчирхийлэл, хайхрамжгүй байдал, сэтгэцийн эрүүл мэндийн сорилт зэрэг үндсэн асуудлуудыг шийдвэрлэх боломжтой. Сургууль, олон нийтийн төв, нийгмийн үйлчилгээний байгууллагууд эрт илрүүлэх систем, зөвлөгөө өгөх үйлчилгээ, зөвлөн туслах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хүүхдүүдэд гэмт хэргийн зан үйлээс өөр хувилбар санал болгох, эерэг хөгжлийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах ёстой.

Хууль сахиулах болон эрх зүйн тогтолцоог чадавхжуулах: Хүүхэдтэй холбоотой хэргийг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд хангалттай нөөц, сургалт, мэргэшсэн нэгжүүдийг хуваарилах нь нэн чухал юм. Эрх зүйн орчныг тогтмол үнэлж, сайжруулснаар хүүхдийн эрхийг хамгаалах ажлыг улам сайжруулах боломжтой гэж үзэж байна.

Ашигласан материал

- Бадамханд Ю. Хүүхдийн эсрэг гэмт явдал. УБ. 2014
- Уголовное право. Особенная часть: Учебник /Под ред.проф. В.Н.Петрашева. - М., 1999
- Цагдаагийн ерөнхий газар. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал – 2021. УБ. 2022
- Эмирбекова Э.Э. Преступления против несовершеннолетних и проблемы их профилактики /по материалам республики Дагестан/. Дис...докт. юрид. наук. М. 2006.